



monlogistics
GROUP

2023

IV ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

WWW.MLHOLDING.MN

MSE: MLG

ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД - 2023



Тээвэрлэсэн ачааны
өсөлт

163%



Эздийн өмчийн
өгөөж / ROE/

25%



Зээл

0 ТӨГРӨГ



Борлуулалтын
орлогын өсөлт

52%



Тээврийн салбарын
нийт ачааны өсөлт

70%



Мөнгө ба түүнтэй
адилтгах хөрөнгө

25 ТЭРБУМ
ТӨГРӨГ



АГУУЛГА

- Эрхэм зорилго, алсын хараа
- Компанийн тухай
- Группийн өсөлтийн зураглал
- Гүйцэтгэх захирлын улирлын дүгнэлт
- Онцлох ажлууд - 2023
- Үйл ажиллагааны тайлан
- Санхүүгийн тайлан
- Ногдол ашгийн тухай



ЭРХЭМ ЗОРИЛГО



Дэлхий рүү тэмүүлэх
үндэсний брэнд

АЛСЫН ХАРАА



Монгол Улсыг Ази,
Европыг холбосон
ложистик төв
болгоно.

ҮНЭТ ЗҮЙЛС



Өндөр
чадвартай,
мэргэжлийн
хамт олон



Инновацлаг
багийн
сэтгэлгээ



Бусдыг
хүчирхэгжүүлэх
манлайллын
соёл



Хариуцлага,
сахилга бат



Ил тод
байдал

МОНЛОЖИСТИКС ГРУПП



МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК
Толгой компани



МОНЛОЖИСТИКС ВОРЛДВАЙД ХХК
Олон улсын тээвэр зууч



МОНЛОЖИСТИКС КАРГО ХХК
Олон улсын карго тээвэр



МОНЛОЖИСТИКС ТРАНЗИТ ХХК
Монгол Улсаар дамжин
өнгөрөх тээвэр



МОНЛОЖИСТИКС ТРАКИНГ ХХК
Олон улсын авто тээврийн
үйлчилгээ



МОНЛОЖИСТИКС ТРАНС СЕРВИС ХХК
ОХУ-д тээврийн үйл ажиллагааг
зохион байгуулагч



КАУС АУСТРАЛИС ХХК
Уул уурхайн бүтээгдэхүүн экспортын
тээвэр зохион байгуулагч



МОНЛОЖИСТИКС РОССИЯ
ХОЛДИНГ ХХК
ОХУ-д тээврийн үйл ажиллагааг
зохион байгуулагч



МОНЛОЖИСТИКС ЭКСПРЕСС ХХК
Олон улсад байрших агентын
тээвэр



МОНЛОЖИСТИКС ЭКЮЙПМЕНТС ХХК
Хөдлөх бүрэлдэхүүний түрээсийн үйл
ажиллагаа

КОМПАНИЙН ТУХАЙ

Монложистикс групп нь 2005 оноос эхлэн тээвэр ложистикийн чиглэлээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд өдгөө 1 толгой компани, 9 охин компани, 200 орчим ажилтан, 163 орны 800 гаруй түнш, дотоодын 1500 гаруй үйлчлүүлэгчтэй салбартаа тэргүүлэх зэрэглэлээр ажиллаж байна.

Бид өнөөдөр Монгол улсад тээврийн салбарын онцлог бүрийг шингээсэн 9 охин компанитайгаар Группийн үйл ажиллагааг өргөжүүлэн, Монгол улсын тээврийн салбарт олон улсын стандартыг нэвтрүүлж, эцсийн харилцагч үйлчлүүлэгчдэдээ хамгийн чанартай, сэтгэл ханамжтай үйлчилгээг хүргэхээр ажилладаг билээ.

Монложистикс Холдинг ХХК нь өөрийн охин компаниудад Хүний нөөц, Санхүү, Мэдээллийн технологи, Маркетинг, Стратеги, Бизнес хөгжил, Ложистик б чиглэлд олон улсын менежментийн үйлчилгээг чанартай үзүүлэхээс гадна, шинэ бизнес төслийг үргэлж эрэлхийлж, Группийг нэг бодлого, зарчимд зангидаж, нэгдсэн стандартын дагуу үйл ажиллагаа явуулдаг толгой компани

ГРУППИЙН ТҮҮХЭН ЗУРАГЛАЛ

2005.11.27 - 2024.01

МОНЛОЖИСТИКС ВОРЛДВАЙД ХХК



Анх 5 ажилтантай Варьете бизнес төвөөс үйл ажиллагаагаа эхлүүлсэн Монголын тээвэр ложистикийн салбарын анхдагчдын нэг өдгөө 9 охин компани, нийт 180 гаруй ажилтан, гадаад, дотоодын 1500 гаруй харилцагч, үйлчлүүлэгчтэй Монложистикс Групп компани болж тэлээд байна.



2010

Монгол Улсын Гаалийн ерөнхий газраас гаалийн зуучлагчийн эрх авлаа.



2011

Монголын төмөр зам компаниас гаргасан судалгаагаар ачаа импортлогч Топ 3 компанийн нэгээр шалгарлаа.



2013

Монголын ТОП 150 аж ахуйн нэгжийн нэгээр шалгарав.



2015

ISO 9001:2008 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, албан ёсны сертификатыг гардан авлаа. Мөн Олон улсын тээвэр зуучийн ассоциацуудын холбооны (FIATA) албан ёсны гишүүнээр элсэв.



2017

Тээврийн TMS 3.0 цахим платформыг хөгжүүлэн, үйл ажиллагаандаа нэвтрүүллээ.




2019

Монложистикс Холдинг групп компани болж үйл ажиллагаагаа өргөжүүллээ.



2023

Монложистикс Холдинг Компани IPO хийж олон нийтэд нээлттэй компани боллоо.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН УЛИРЛЫН ДҮГНЭЛТ

Эрхэм уншигч, хувьцаа эзэмшигч та бүхэн Монложистикс Группийн 2023 оны жилийн эцсийн тайланг хүлээн авна уу. Өнгөрсөн 2023 онд нийт Монложистикчууд, хамтран ажиллагч байгууллага, үнэнч хэрэглэгчдийн хамтын ажиллагаа, хүчин чармайлтын үр дүнд бидний нийт тээвэрлэсэн ачаа тээврийн хэмжээ 163%-р өсөж 1 сая тонн хүрсэн нь компанийн түүхэн рекордыг шинэчлэн тогтоосон амжилттай жил болж өнгөрлөө. Энэхүү үр дүнг бий болгоход тууштай хүчин чармайлт гаргасан хамт олон, үргэлж хамт байсан хэрэглэгчид, дэмжиж ирсэн хувьцаа эзэмшигчид болон үргэлж найдвартай байдаг түншүүддээ талархал илэрхийлье. Өөрийн 18 жилийн туршлага, дэлхийн 160 гаруй орны түншийн сүлжээ, найдвартай үйлчилгээгээр дамжуулан бид Монгол улсын эдийн засгийн гол судас болох тээвэр ложистикийн салбарт тодорхой үнэ цэнэ, инновац, шинэчлэлийг бий болгож улмаар улсын эдийн засагт гарч буй эерэг үзүүлэлтүүдэд хувь нэмрээ оруулж байгаад баяртай байна.



Хэдийгээр жилийн эцсийн үр дүнд үйл ажиллагаа өргөжиж, өндөр өсөлтийг бий болгосон ч 2023 онд бид бүхэн олон томоохон сорилтууд, тодорхой бус байдалтай тулгарсныг мөн дурдах нь зүйтэй. Дэлхийн тээвэр ложистикийн үнэ эрчимтэй буурч улмаар дундаж ашгийн түвшин буурсан, импортын сегментийн өрсөлдөөн ширүүсэж, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн шинэ төмөр замын экспорт тээвэр хаагдаж, дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ буурсан, Төмөр замын тээврийн тухай хуулийн хэрэгжилт хойшлох, инфляцын дарамт зэрэг олон сорилтуудтай тулгарч бид олон зүйлийг сурч мөн арвин туршлагыг хуримтлууллаа. Гэсэн ч Монложистикс групп 18 жилийн өсөлтийн түүхээ үргэлжлүүлж 2023 онд зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэн ажиллаа.

Дээрх бизнес, үйл ажиллагааны өсөлтийн хажуугаар бидний бас нэгэн хэрэгжүүлсэн чухал ажил бол ирээдүйн тэлэлт, өсөлтөд бэлдэж стратегийн чухал нөөцүүдийг амжилттай бүрдүүлэх ажил байлаа. 2023 онд IPO хийх замаар хөрөнгө татан төвлөрүүлсэн мөн санхүүгийн болон бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтүүдийг амжилттай хийсний үр дүнд групп 2023 оны эцсийн байдлаар нийт 25 орчим тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгөтэй ба ямарваа өр, зээлгүйгээр жилийг хаалаа. Энэ нь салбарын эрчимтэй өсөн хөгжиж буй энэ эгзэгтэй ба боломжоор дүүрэн цаг мөчид компанийн ирээдүйн өсөлтийг бүрдүүлэх хөрөнгө оруулалтуудыг хийх стратегийн маш том давуу талыг бидэнд олгож байгаа юм. Тиймээс 2024 оноос бид хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг идэвхжүүлж эхлэх бөгөөд үүнд хөдлөх бүрэлдэхүүн, хүнд дэд бүтэц болон компани худалдан авах ба нэгдэх зэрэг олон хувилбарууд дээр яг одоо ажиллаж байна.

2024 онд Монложистикс групп бүрэн бүрэлдэхүүнээр өсөлт болон тогтвортой хөгжил гэх хоёр үндсэн зорилтын хүрээнд олон стратегийн ажлуудыг төлөвлөсөн, завгүй жил байхаар төлөвлөж байна. Монгол улсын богино, дунд хугацааны макро эдийн засгийн эерэг хүлээлт нь мөн хөрөнгө оруулалт хийхэд таатай орчныг бүрдүүлж байгаа учраас бид энэ жил олон шинэ мэдээ, бүтээгдэхүүн үйлчилгээтэйгээр хэрэглэгч, хөрөнгө оруулагч нартайгаа уулзана гэдэгт итгэлтэй байна. 2024 оны 4-р сард зохион байгуулагдах ээлжит Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр уулзацгаая!

Монложистикс Холдинг ХХК
Гүйцэтгэх захирал **Г.Хишигбат**

ОНЦЛОХ ТЭЭВЭР



monlogistics
WORLDWIDE

Монложистикс Ворлдвайд Компани БНХАУ-ийн Нанжин хотод зохион байгуулагдсан “Edges as the Center: Border Rivers, Bridges and Memory Spaces” олон улсын үзэсгэлэнд зориулсан Монгол уран бүтээлчийн баримлыг амжилттай тээвэрлэж гүйцэтгэлээ.

monlogistics
WORLDWIDE

Монложистикс Ворлдвайд 2023 оны 4-р улиралд АВСТРИ Улс руу агаараар “УРАНЫ ДЭЭЖ” Аюултай ачааг амжилттай тээвэрлэж гүйцэтгэлээ.

monlogistics
TRANSIT

Монложистикс Транзит Компани Монложистикс Тракинг Компанитай хамтран БНХАУ-ын Шандунг мужаас ОХУ-ын Нижневартовск хот хүртэл 15ш том оврын ачааны машинаар 7000 км “Автозамын Транзит” тээвэр зохион байгууллаа.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Монложистикс Холдинг ХК

Монложистикс Холдинг Компани 2023 оны 12 сарын 22 нд албан ёсоор “Хувьцаат Компанийн” гэрчилгээ, тэмдэгийг гардаж авлаа.



ESOP Хөтөлбөр

“Монложистикс Холдинг” ХК Группийн бүх ажилтнууддаа ESOP (Employee stock ownership plan) хөтөлбөрийг албан ёсоор олон улсын жишигт нийцүүлэн хэрэгжүүлж эхэллээ.



ISO 9001 Хөтөлбөр

Монложистикс Групп нь өөрийн 6 охин компанидаа ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны олон улсын стандартыг нэвтрүүлэх төслийг нэгдсэн байдлаар эхлүүллээ.



Хувьцаа эзэмшигчдийн хурал

Монложистикс Холдинг Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2023 оны 11 сарын 18-нд цахим хэлбэрээр амжилттай болж өндөрсөн бөгөөд тус хурлаар 4 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.



Do Good Hub Шинэ гишүүд авлаа

Монложистикс Групп нийгмийн хариуцлагын хүрээнд үүсгэн байгуулж буй Do Good Hub өнгөрсөн улиралд үйл ажиллагаагаа улам өргөжүүлж шинэ 8 ТББ-тай хамтын ажиллагааны гэрээ байгууллаа.




monlogistics
HOLDING

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

- *Тээврийн салбарын нийт орлого*
- *Монложистикс Группийн орлого*
- *Тээврийн салбарын ачааны нийт хэмжээ*
- *Монложистикс Группийн ачааны хэмжээ*

ТЭЭВРИЙН САЛБАРЫН ОРЛОГО

/ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР/




2023 оны 4-р улирлын байдлаар тээврийн салбарын орлого 6.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 52% өссөн байна.

**Статистикийн үндэсний хорооноос 2023 оны 10 сард Тээвэр ложистикийн салбарын орлогыг тооцох аргачлалыг шинэчилсэн тул 2021-2023 оны тоон үзүүлэлтүүд өөрчлөгдсөн болно.*


МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН ОРЛОГО

/ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР/




Монложистикс группийн нийт орлого 213.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 52% өсөлттэй байгаа нь салбарын өсөлтийн хувьтай тэнцүү байна.

ТЭЭВРИЙН САЛБАРЫН НИЙТ АЧААНЫ ХЭМЖЭЭ /МЯНГАН ТОННООР/




Тээврийн салбарын 2023 оны 4-р улирлын байдлаар нийт ачаа тээврийн эргэлтийн хэмжээ 103 сая.тн хэмжээнд хүрч өмнөх мөн үетэй харьцуулахад 70% өссөн байна.

МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН АЧААНЫ ХЭМЖЭЭ /МЯНГАН ТОННООР/




Монложистикс группийн ачаа эргэлт 1.04 сая.тн хүрч өмнөх оны мөн үеэс 163% өссөн байна.

ЭКСПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ /МЯНГАН ТОННООР/




Монгол улсын экспортын ачаа тээвэр өмнөх оноос 94% өсөж 78сая.тн түүхэн дээд хэмжээнд хүрсэн байна.




Монложистикс группийн экспортын ачаа тээвэр өмнөх мөн оны үеэс 130% өсөж 157.3 мянган.тн хүрсэн байна.

ИМПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ /МЯНГАН ТОННООР/




Монгол улсын импортын ачаа тээвэр өмнөх оны мөн үеэс 45% өсөж 7.2сая.тн хүрсэн байна.




Монложистикс группийн импортын ачаа тээвэр өмнөх мөн оны үеэс 12% буурч 98 мянган.тн хүрсэн байна.

ТРАНЗИТ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ /МЯНГАН ТОННООР/




Монгол улсаар дамжин өнгөрдөг транзит ачаа тээвэр өмнөх оны мөн үеэс 61% өсөж 5.1 сая.тн хүрсэн байна.



Монложистикс группийн зохион байгуулдаг транзит ачаа тээвэр өмнөх оны мөн үеэс 278% өсөж 768 мянган.тн хүрсэн байна.

ОЛОН УЛС ДАХЬ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ /МЯНГАН ТОННООР/



Монложистикс группийн гадаад улс доторх ачаа тээврийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 44% өсөж 19 мян.тн хүрсэн байна.



monlogistics
HOLDING

— САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- *Нэгтгэсэн санхүү байдлын тайлан*
- *Нэгтгэсэн орлогын тайлан*

Нэгтгэсэн санхүү байдлын тайлан

сая төгрөгөөр

	2021 restated	2022 restated	2023	YoY	%
Мөнгөн хөрөнгө	5,803	14,198	22,122	7,924	56%
Дансны авлага	12,815	15,832	17,256	1,423	9%
Бусад авлага	870	2,584	3,379	795	31%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	-	-	2,461	2,461	
Урьдчилж төлсөн төлбөр	4,247	5,662	6,050	389	7%
Бусад эргэлтийн хөрөнгө	1,150	1,472	2,842	1,370	93%
Эргэлтийн хөрөнгийн дүн	24,884	39,748	54,109	14,361	36%
Үндсэн хөрөнгө	1,216	1,449	1,523	74	5%
Ашиглах эрх бүхий хөрөнгө	305	163	857	694	426%
Бусад эргэлтийн бус хөрөнгө	4	761	1,194	434	57%
Эргэлтийн бус хөрөнгийн нийт дүн	1,525	2,372	3,574	1,201	51%
Нийт хөрөнгийн дүн	26,409	42,120	57,683	15,563	37%
Дансны өглөг	4,312	9,720	8,888	(832)	-9%
Татвар НД-н өр төлбөр	1,023	1,389	1,167	(223)	-16%
Урьдчилж орсон орлого	337	1,558	837	(722)	-46%
Богино хугацаат зээл	-	2,800	20	(2,780)	-99%
Бусад өглөг	887	1,294	2,572	1,278	99%
Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,560	16,762	13,483	(3,279)	-20%
Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,721	210	722	512	244%
Нийт өр төлбөр	8,281	16,972	14,204	(2,767)	-16%
Эздийн өмч	16,536	23,202	39,238	16,036	69%
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	1,593	1,947	4,241	2,295	118%
Нийт Эздийн өмч	18,128	25,149	43,479	18,330	73%
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	26,409	42,120	57,683	15,563	37%

Нэгтгэсэн орлогын тайлан

сая төгрөгөөр

	2021 restated	2022 restated	2023	YoY	%
Борлуулалтын орлого	89,472	136,090	213,518	77,428	57%
Борлуулалтын өртөг	(80,624)	(119,548)	(195,139)	(75,592)	(63%)
Нийт ашиг	8,848	16,543	18,379	1,836	11%
Үйл ажиллагааны зардал	(5,631)	(6,473)	(8,677)	(2,205)	34%
Үйл ажиллагааны цэвэр ашиг	5,217	10,070	9,481	1,203	-4%
Үйл ажиллагааны бус орлого (зардал)	(65)	974	140	(835)	-86%
Татварын өмнөх цэвэр ашиг (ЕВТ)	5,152	11,044	9,841	(1,203)	-11%
ОАТ-н зардал	(743)	(1,565)	(1,196)	369	-24%
Цэвэр ашиг	4,409	9,480	8,646	(834)	-9%
Толгой компанийн хувь эзэмшигчдэд ногдох ашиг	4,002	8,156	6,205	(1,951)	-24%
Хяналтын эрхгүй хувь оролцоо	407	1,323	2,441	1,118	84%



МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК

НОГДОЛ АШИГ ТАРААНА */MSE: MLG/*

НИЙТ АШГИЙН 35%

НИЙТ 3,000,609,870,76₮

НЭГЖ ХУВЬЦААНД 7.58₮

НОГДОЛ АШИГ
ТАРААХ ӨДӨР 2024.06.28

+976 7701-5454

www.mlholding.mn

info@mlholding.mn

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ:

“Монложистикс Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 07 -ны өдрийн №24/ТУЗ/06 тоот тогтоолоор компанийн 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгийн 35% хувийг буюу нийт 3,000,609,870,76 /гурван тэрбум зургаан зуун есөн мянга найман зуун далан төгрөг далан зургаан мөнгө/ төгрөгийг, нэгж хувьцаанд 7,58₮ /долоон төгрөг тавин найман мөнгө/ төгрөгөөр тооцож, нийт хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг олгохоор шийдвэрлэлээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг компанийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тогтооно.

Ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд 2024 оны 06 дугаар сарын 28-ний өдрийн дотор олгохоор шийдвэрлэлээ.



monlogistics
HOLDING

ХОЛБОО БАРИХ

+976 7701-5454

info@mlholding.mn

www.mlholding.mn

1101, Нью Хоризонс оффис, Олимпын гудамж, 1-р хороо,
СБД, Улаанбаатар, Монгол Улс

